



ЦАХИЛГАДН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СУЛЖЭЭ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ

**“АШ-105, 106-н 3 ТӨГСГӨЛИЙН ҮНДСЭН ХАМГААЛАЛТАД
ШААРДЛАГАТАЙ РЕЛЕ ХАМГААЛАЛТЫН МАТЕРИАЛ
НИЙЛҮҮЛЭХ” НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ
ХАРЬЦУУЛАЛТЫН ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Тендерийн дугаар: ЦДУС- УБС-2019/ХА-06 дахин

Улаанбаатар хот
2019 он

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Огноо: 2019 оны 12 дүгээр сарын 09-ны өдөр

“Цахилгаан Дамжуулах Үндэсний Сүлжээ” ТӨХК-ийн Улаанбаатар салбар нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогдоос “**АШ-105, 106-н 3 төгсгөлийн үндсэн хамгаалалтад шаардлагатай реле хамгаалалтын материал нийлүүлэх**” үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2019** оны **12** дугаар сарын **16**-ны өдрийн **11:00** цагаас өмнө Төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим системээр илгээнэ.

Үнийн саналыг **2019** оны **12** дүгээр сарын **16**-ны өдрийн **11:10** цагт Төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим системээр системээр нээнэ.

Дотоодын давуу эрх тооцохгүй.

Улаанбаатар-17060, Баянгол дүүргийн 20 дугаар хороо, Эрчим хүчний гудамж 26/1 тоот “ЦДУС” ТӨХК-ийн Улаанбаатар салбарын байр

Утас: 70041655, 99062941

Email: buiqaas@yahoo.com

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- | | |
|---------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа | 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна. |
| 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт | 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна. |
| 3. Тендерийн иж бүрдэл | 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
3.1. Тендерт оролцгчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

(а) Унийн санал;
(б) Унийн болон нийлүүлэлтийн хуваарь;
(в) Чадварын мэдээлэл. Үүнд:

- Сүүлийн нэг жилийн санхүүгийн тайлан /аудитын дүгнэлтийн хамт/;
- Татварын цахим тодорхойлолт;
- Сүүлийн нэг жилийн туршлагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/;
- Улсын бүртгэлийн гэрчилгээ; /нотариатаар баталгаажуулсан/
- Компанийн танилцуулга;

(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл; |
| 4. Тогтмол үнэ | 4.1. Тендерт оролцгчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Унийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн санаалаас татгалзана. |
| 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд | 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ. |
| 6. Унийн саналын хүчинтэй байх хугацаа | 6.1. Унийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна. |

- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **TШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТОӨЗ-НЫХОЛБОГОХ ЗААЛТ	Шалгуур үзүүлэлт
ТОӨЗ 1.1	<ul style="list-style-type: none"> - Сүүлийн нэг жилийн санхүүгийн тайлан - Татварын цахим тодорхойлолт - Сүүлийн нэг жилийн туршлагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээ, гүйцэтгэлийн акт бичиг баримтын хуулбар/; - Улсын бүртгэлийн гэрчилгээ; - Компанийн танилцуулга. - Санал болгож буй бараа нь үйлдвэрийн бүтээгдэхүүн - Санал болгож байгаа барааны гарал үүслийн гэрчилгээ - Санал болгож байгаа бараа материалын техникийн үзүүлэлт, танилцуулга, фото зураг <p>Дээр дурдсан материалын аль нэгийг ирүүлээгүй тохиолдолд тухайн тендерээс татгалзах үндэслэл болно.</p>
ТОӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn</p> <p>Огноо: Тендерийг 2019 оны 12 дугаар сарын 16-ны өдөр Цаг: 11 цаг 00 минут.</p>
ТОӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх хугацаа нь:</p> <p>Огноо: 2019 оны 12 дугаар сарын 16-ны өдөр нээлт хийнэ. Цаг: 11 цаг 10 минут</p>
ТОӨЗ 7.2	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: багцгүй

Дөрөв. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ /БАРААНЫ ЖАГСААЛТ/

Батлав: ЦДУС ТӨХК –н Улаанбаатар
салбарын ерөнхий инженер:



Д.ЖААВАЙ

ИХБ-4-ын 110 кВ-ын Шин ТойТ-1-ын механик хамгаалалтгыг микропроцессорын хамгаалалттай зэрэгцээ ажиллагаанд оруулах, АШ-118-д байгаа SEL-311L релег авч АШ-105,106 шугамыг 3 төгсгөлийн үндсэн хамгаалалт оруулахад шаардлагатай микропроцессорын реле хамгаалалтын техникийн шаардлага.

ИХБ-4-ын 110 кВ-ын ШОВ-1-ын ОВ-ын горимд одоогийн ашиглагдаж байгаа цахилгаан механик реле хамгаалалттай зэрэгцээ ажиллагаанд ажиллах бүрэн боломжтой үндсэн хамгаалалт болон Баруун дэд станцын СХТ-110-ын бэлтгэл реле хамгаалалтын микропроцессорын төхөөрөмжүүдийг тус тус нийлүүлэх техникийн тодорхойлолт.

ДД	Ерөнхий шаардлага	Тайлбар
НЭГ. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА		
1.	Орчин үеийн RXA-ийн систем шаардлагдах шаардлагыг хангасан байх.	МУ-н ЭХС-н хэмжээнд мөрдөгдөж байгаа "Цахилгаан байгууламжийн дүрэм"-д нийцэж ажиллах, монгол улсын MNS стандарт болон олон улсын IEC, IEEE, ГОСТ-ын стандартуудын техникийн шаардлага хангасан RXAB-н төхөөрөмжүүдийг сууринуулах. Эдгээр солигдох төхөөрөмж нь 110 кВ ба түүнээс дээш хүчдлийн тувшинд мөн систем үүсгэгч шугаманд ашиглагдаж байгаа хуучин нийлмэл реле хамгаалалтын логик, ажиллах зарчмыг бүрэн хангаж, хамт нийцэж ажиллах бүрэн бололцоотой, сууринлагдах дэд станцын ашиглалтанд байгаа нийлмэл хамгаалалтуудтай бүрэн зохицож ажиллах /УРОВ, ДЗШ, АВТОМАТИК/ бололцоотой байх МИКРОПРОЦЕССОРЫН РЕЛЕ ХАМГААЛАЛТЫН ТӨХӨӨРӨМЖ сонгох. МП-ийн RXA –н төхөөрөмжийн тусламжтайгаар дотоод хяналтын системийг /HMI/ үүссэх бүрэн бололцоотой байх, IEC стандартын нэгдсэн протоколыг дэмждэг байх. Мөн тухайн дэд станцын таслуур, хуурай салгуур, газардлагын хүтгэг алсаас болон байрнаас удирдах боломжтой, компьютер удирдлагын болон гадаад хэвийн горимийн /СКАДА болон мониторингийн системүүд/ хяналтын системд бүрэн дэмждэг байх шаардлагатай.
2.	RXA –н төхөөрөмжийн хуучин ажиллаж байсан зарчмыг алдагдуулхгүйгээр эсвэл дэмжийэг байх шаардлагатай..	Одоо ажиллаж байгаа логик ажиллагааг алдагдуулхгүйгээр ажиллах техникийн болоод программ хангамжын уян хатан боломжтой байх, угсралтын үед удирдлага, автоматик дохиололын хэлхээг одоо ашиглагдаж байгаа тоноглолуудтай бүрэн уялдуулан ажиллана.
3.	Тавигдах төхөөрөмж нь дараах хамгалалтуудын функцуудээр хангагдсан	RXA-ийн төхөөрөмж нь тухайн шугам дээр болон түүнээс тэжээгдэж байгаа хэлхээн дээр үүссэн бүх төрлийн богино залгааны гэмтлийн үед мэдэрч ажиллан шугамыг системээс тусгаарлах үүрэгтэй.

	байх шаардлагатай.	Үндсэн болон бэлтгэл хамгаалалтууд нь суурилагдах ба тэдгээр нь заавал өөр хоорондоо үл хамаарах тэжээлийн үүсгүүртэй, харилцан биенээ орлох бололцотой тус тусдаа бие даасан байна. Одоо ашиглагдаж байгаа хөндлөн дифференциал хамгаалалтыг орлох дагуу дифференциаль хамгаалалтын функцийн төхөөрөмжүүдийг голлон сонгоно.
ХОЁР. ТЕХНИКИЙН ШААРДЛАГА		
4.	Үндсэн хамгаалалтын төхөөрөмжинд байх шаардлагатай RXA-ийн функцийн горимууд.	<ul style="list-style-type: none"> • 21G Зайн хамгаалалт газардлагын B3 • 21P Чиглэл оруулах боломж бүхий зайн хамгаалалт • 27 Хүчдэл бууралтын хамгаалалт • 50N/G Тэг дараалалын гүйдлийн чиглэлтэй хамгаалалт • 50P Фазын гүйдлийн хамгаалалт • 50Q Урвуу дараалалын гүйдлийн чиглэлтэй хамгаалалт • 51N/G Газардлагын чиглэлтэй гүйдлийн хугацааны барилттай хамгаалалт • 59 Хүчдэл ихсэлтийн хамгаалалт • 59N – тэг дараалалын хүчдэл хяналтын реле • 67N/G Газардлагын чиглэлтэй гүйдлийн хамгаалалт • 67P Фаз хоорон дахь B3 –ны гүйдлийн хамгаалалт • 67Q Урвуу дараалалын гүйдлийн хамгаалалт • 81 Давтамжийн өөрчлөлтийн хамгаалалт • 27TN – Хүчдэл бууралтын реле; • 32 – чадлын чиглэлийн реле ; • 50BE – таслуур татгалзах үеийн хамгаалалт; /УРОВ/ • 68 – савлалтын хориг /power swing block/ • Хэт ачаалалын ерөнхий хяналт • B3 буюу гэмтэлтэй тоноглолыг залгах үед хамгаалалтын хурдасгах хэлхээ • Нэг фазын таслалт хийх бололцоотой • Хяналтын кабелийн хяналттай • Тэжээлийн хүчдэл ≈125-250 В, 47-63 Гц, <90 ВА (max) • Ажиллах температур -40°C +55°C
5.	Бэлтгэл хамгаалалтын төхөөрөмжинд байх шаардлагатай RXA-ийн функцийн горимууд.	<ul style="list-style-type: none"> • 27 Хүчдэл бууралтын хамгаалалт • 50N/G Тэг дараалалын гүйдлийн чиглэлтэй хамгаалалт • 50P Фаз гүйдлийн хамгаалалт • 50Q Урвуу дараалалын гүйдлийн хамгаалалт • 51N/G Газардлагын чиглэлтэй гүйдлийн хугацааны барилттай хамгаалалт

		<ul style="list-style-type: none"> • 59 Хүчдэл ихсэлтийн хамгаалалт • 59N – тэг дараалалын хүчдэл хяналтын реле • 67N/G Газардлагын чиглэлтэй гүйдлийн хамгаалалт • 67P Фаз хоорон дахь Б3 –ны гүйдлийн хамгаалалт • 67Q Урвуу дараалалын гүйдлийн хамгаалалт • 81 Давтамжийн ёөрчлөлтийн хамгаалалт • 27TN – Хүчдэл бууралтын реле; • 32 – чадлын чиглэлийн реле; • 50BF – таслуур татгалзах үеийн хамгаалалт; /УРОВ/ • Хэт ачаалалын ерөнхий хяналт • Б3 буюу гэмтэлтэй тоноглолыг залгах үед хамгаалалтын хурдаасгах хэлхээ • Нэг фазын таслалт хийх бололцоотой • Хяналтын кабелийн хяналттай • Тэжээлийн хүчдэл $\geq 125-250$ В, 47-63 Гц, <90 ВА (max) • Ажиллах температур $-40^{\circ}\text{C} +55^{\circ}\text{C}$
6.	Үндсэн хамгаалалтын төхөөрөмжинд байх удирдлагын функцийн горимууд.	<ul style="list-style-type: none"> • 79 Дахин залгах автоматик • 79S Нэг фазын дахин залгах автоматик • 25 Синхрон хийж залгах • CONTROL Дэлгэцнээс удирдах • HMI Байрнаас болон алсаас удирдах бололцоотой • BM Таслуурын ресурсын хяналттай • Таслуурын таслах ороомгийн хяналт • SER Үйл явдалын тухай дүгнэлт • EVENT Аваарийн үеийг бичигч, бүртгэгч • IEC61850 протокол • Шугамын гэмтлийн зайн тодорхойлох функцтэй байх • Таслуур болон бусад холбогдох дохиоллыг хүлээн авах боломж бүхий оролтуудтай байх
		•
ГУРАВ. ХҮЛЭЭЛГЭН ӨГӨХ ШААРДЛАГА		
7.	Хамгаалалтын төхөөрөмжийн бүх функцийн ажиллагааг хянах, түүний ажиллагааг ажиллуулж шалгаж батлагдсан протокол үйлдэх.	<ul style="list-style-type: none"> • Гүйдлийн хэлхээг 0,1-100 А хүртэл • Хүчдэлийн хэлхээг 0,5-242 В • Хугацааны тавилыг 0,05-300 сек • Тэжээлийн блок /доод – дээд/ хязгаарын хурдаанд ажиллуулсан байх • Унтраад асах үеийн хурдыг хэмжсэн байх. • Б3 –н дээр хамгаалалтыг залгах үед таслах хурд. • Залгах үеийн импульсийн гүйдлийн хэмжээ. • Б3 –ны үед гүйдлийн трансформатор ханалтын

БАРААНЫ ЖАГСААЛТ, БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН БОЛОН УГСРАЛТ СУУРИЛУУЛАЛТЫН ХУВААРЬ

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх, угсарч суурилуулах эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлж, угсарч суурилуулах хамгийн эхний хугацаа	Нийлүүлж, угсарч суурилуулах эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
1							
2							
3							
4							
5							

Тав. ЖИШИГ МАЯГТ

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

**Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн Улаанбаатар
салбарын дарга Ч.Мөнхпүрэв танаа**

- Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгэээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлж, угсарч суурилуулахаар санал болгож байна.
- Нийлүүлж, угсарч суурилуулах бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
- Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ, ₮	Нийт дүн, ₮	НӨАТ болон бусад албан татвар, ₮	Бүгд дүн, ₮
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ, ₮							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХУСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээнлэсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаarahгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Зургаа. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|-----------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1. Шалгах болон турших | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэж угсарч суурилуулагдах бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа 1 жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш (ГТН-д заасан тоо) хоногийн дотор шуурхай хийнэ. |

- | | |
|--------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 8. Бараа
нийлүүлэх
хуваарь | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги
оногдуулах | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ
биелүүлээгү
й-гээс
гэрээг
цуцлах | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг
шийдвэрлэх | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Долоо. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- | | |
|---------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1. Шалгах болон турших (ГЕН – 1) | 1.1. Захиалагч барааг хүлээн аваходаа техникийн үзүүлэлт, тоо ширхэг, бүрэн хангаж байгаа эсэхийг шалган хүлээн авна. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) | 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд: <ol style="list-style-type: none">1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;5) барааны гарал үүслийн гэрчилгээ.6) Угсарч суурилуулан ашиглалтад оруулсан тухай акт баримт |
| | Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна. |
| 3. Баталгаат засвар (ГЕН-5) | 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
Чанарын баталгаат хугацаа 12 сар байна. Чанарын баталгааны барьцаа 5 хувь, |
| 4. Төлбөр (ГЕН – 7) | 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:

Гэрээний үнийн дүнгийн 95 хувийг барааг хүлээн авсан болон гэрээ дүгнэж акт үйлдсэн баримт бичгийг үндэслэн төлнө. Чанарын баталгааны барьцаа 5 хувийг гэрээ дүгнэсэн өдрөөс хойш 6 сарын дараа олгоно. |
| 5. Алданги оногдуулах (ГЕН - 9) | 9.1. Алданги оногдуулах хувь: Хоног тутамд гэрээний үнийн дүнгийн 0.05% байна.
Алдангийн нийт дүн: Гэрээний үнийн дүнгийн 5%-иас хэтрэхгүй. |

Найм. ГЭРЭЭНИЙ МАЯГТ

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[АШ-105, 106-Н З ТӨГСГӨЛИЙН ҮНДСЭН ХАМГААЛАЛТАД ШААРДЛАГАТАЙ РЕЛЕ ХАМГААЛАЛТЫН МАТЕРИАЛ НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ]

Дугаар № [ЦДУС- УБС-2019/ХА-02]

.....
хот/аймаг

Нэг талаас **Цахилгаан Дамжуулах Үндэсний Сүлжээ ТӨХК-ийн Улаанбаатар салбар** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [**нийлүүлэгчийн нэр**] (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____оны_сарын_-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

- Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
- Захиалагч нь [**гэрээний нэр, дугаар**]-г (цаашид “бараа” гэх) [**гэрээний үнийг тоогоор болон үсгээр**] (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлж угсарч сууринуулахаар ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
- Захиалагч нь барааны нийлүүлэлт, угсралт сууринуулалтын ажлыг

_____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____
төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн
өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.

4. Нийлүүлэгч НЬ
НЭР
төрлийн барааг _____ оны ____ дугаар сарын ____ -наас _____ оны
дугаар сарын -ны өдрийн дотор нийлүүлж угсарч суурилуулан хүлээлгэж
өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид
“гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
Бусад шаардлагатай баримт бичиг
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын
хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг
орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвэл дээр
дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.
6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг
үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан
барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон
гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед
гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр
нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс,
цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг]

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг]

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]